БАТЛАВ
СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД

# НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ ЗАМ ТАЛБАЙН ЯВГАН ЗАМ ЗАСВАРЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Дугаар 4.... Улаанбаатар хот

| | | |
|---|---|---|
| 1 | Ерөнхий зүйл | Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн явган зам засварлах ажлын төрөл хэмжээг стандарт, шаардлагын дагуу гүйцэтгэнэ. |
| 2 | Барилгын талбайн /замын зурвас/-н үзүүлэлт | Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн эвдрэлтэй явган зам талбай БАГЦ-4 |

| № | Ажил | Хороо | Талбайн хэмжээ /м2/ | Нэгж үнэ 70.000 /м2/ | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | 14, 15, 16 дугаар хорооны нийтийн эзэмшлийн гудамж талбайн явган хүний зам засварлах ажил | 14-р хороо | 1275 | 89,250,000 | Нийтийн эзэмшлийн гудамж талбай |
| 2 | | 15-р хороо | 320 | 22,400,000 | Нийтийн эзэмшлийн гудамж талбай |
| 3 | | 16-р хороо | 500 | 35,000,000 | Нийтийн эзэмшлийн гудамж талбай |
| | **Нийт** | | **2,095** | **146,650,000** | |

**3. Ажлын цар хүрээ**

Төрөл-1
Явган хүний хавтан жигд өнгөтэй байх бөгөөд хавтангийн чулуу нь ил гараагүй завсаргүй тэгш байхаас гадна явган хүн халтирахаас хамгаалсан барзгар гадаргуутай байна. Явган хүний замын хучилтыг өнгөт хавтангаар хийхдээ технологийн дагуу хийж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан MNS 605652009 стандартыг хангасан байна. Харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан хөтөч хавтанг явган хүний замыг голлон байрлуулна. Явган хүний гарцыг явган хүний хөдөлгөөний хамгийн урсгалттай газраар төлөвлөнө.

- Тохиромжгүй материалуудыг зайлуулах
- Буталсан чулуун суурь -20см
- Зохистой найрлага бүхий хайрган суурь-20см
- Өнгөт хавтан-6см

Төрөл-2.
Явган хүний замын хучилтыг боржин чулуу шигтгэн хийнэ. Шигтгэмэл чулууг технологийн дагуу хийнэ. Явган хүний гарцыг явган хүний хөдөлгөөний хамгийн их урсгалттай газраар төлөвлөнө.

- Буталсан чулуун суурь-20см
- Фементээр багсарсан суурь-20см
- Байгалийн чулуун хучилт-10см

Төрөл 3:
Бетон хучилт нь М125 маркийн бетон зуурмагаар хийнэ. Зуурмагийн чулуу нь ил гараагүй засваргүй тэгш байхаас гадна 1,5м тутамд хэв гажилтын заадсыг гаргаж өгнө. Явган хүний гарцыг явган хүний хамгийн урсгалттай газраар төлөвлөнө.

- Хайрган үе-15см
- Бетон хучилт-10см

Төрөл-4

| | | |
|---|---|---|
| | | MNS:1592:2009 стандартад нийцсэн нарийн ширхэгтэй асфальтон хучилт нь 3 см зузаантай хийж гүйцэтгэнэ. Явган хүний замын гадаргуу жигд тэгш хэмтэй байхаас гадна битум нь хөөрч гадаргуу дээр ил гарч ирээгүй байх, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч тэмдэглэгээг термопласт будгаар хийнэ.<br>- Хөлдөлтөөс хамгаалах үе-15см<br>- Буталсан чулуун үе-10см<br>- Асфальтбетон хучилт-3см |
| 4 | Ажлын хил хязгаар | Сүхбаатар дүүргийн 14, 15, 16 дугаар хороо |
| 5 | Барилгын ажлын зохион байгуулалт | 19) Явган нүний замын ажлыг зохион байгуулахдаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх арга хэмжээ авч хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал /түр зам, тэмдэг тэмдэглэгээ/-ыг бүрэн хангаж ажиллана.<br>20) Гүйцэтгэгч байгууллага " Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газар/-аас баталсан Явган хүний зам талбайн төлөвлөлт хучилтын хавтан тавигдах техникийн ерөнхий шаардлагыг засвар шинэчлэлтийн ажлынг гүйцэтгэх хугацаанд чанд мөрдөн ажиллана.<br>21) Явган хүний замын ажлыг хариуцан ажиллах инжежнер, техникийн ажилчид нь уг ажлыг эхлэхээс ашиглалтад хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд энэ төслөөс өөр бусад төсөлд давхар ажиллахгүй болохыг анхаарч хүн хүч, машин механизмийн хуваарилалтыг графикийг батлуулж ажиллана.<br>22) Гүйцэтгэгч байгууллагын товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх дуусах хугацааг мэдээллийн самбарт үзүүлж олон нийтэд үзэгдэхүйц газар байршуулна.<br>23) Ажлыг батлагдсан төлөвлөгөө, аргачлалын дагуу гүйцэтгэнэ.<br>24) Ажил гүйцэтгэх төлөвлөгөөнд шаардагдах хүн хүчний графийг хамтатган батлуулна. |
| 6 | Арчлалт хамгаалалт | Гүцэтгэсэн ажлыг баталгаат хугацаанд өөрийн хөрөнгөөр засвар, арчлалтыг тогтмол гүйцэтгэнэ. |
| 7 | Бусад | Явган хүний замын ажил дууссан өдрөөс хойш 21 хоногийн дотор гүйцэтгэлийн баримт бичгийг захиалагчид цаасаар болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгнө.<br>Ажлын үе шат бүрт нэг цэгээс фото зураг авч далдлагдсан ажил бүр дээр акт бичиж, инжежнерээр баталгаажуулна.<br>Явган хүний замын ажлын хэмжээг м2-аар хэмжинэ.<br>Тухайн ажлыг эхлэн бариулсан инженер техникийн ажилтан тус ажлыг бүрэн дуусгаж, баримт бичгийг бүрдүүлэн ажил хүлээлцэх комисс ажилуулж, ашиглалтад хүлээлгэн өгнө. |

Хянасан ТНААХ-ийн дарга Т.Эдмон

Боловсруулсан: ТНААХ-ийн мэргэжилтэн Ц.Бэлгүдэй